

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.15 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/295 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам”-ын 4.5-д “... ёс зүй, хууль эрх зүйн багц цагийн богино хугацааны сургалтад таван жил тутам...” гэснийг “нэг жил” гэж өөрчилсүгэй.

2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хууль эрх зүйн багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдах хугацаа нэг жил болж өөрчлөгдөж байгаатай холбоотой журмын өөрчлөлтийг нийт эрүүл мэндийн байгууллагад сурталчлан таниулах, хэрэгжилтэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Туяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо (Д.Оюунбилэг)-нд тус тус даалгасугай.

3. Энэхүү журмын өөрчлөлтийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Туяа)-т даалгасугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

Зөвшөөрсөн:

Д.Очирбат, ТНБД

Хянасан:

Б.Туяа, БТГ-ын даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

А.Мөнхнасан, ТЗУГ-ын мэргэжилтэн

Боловсруулсан:

Ө.Энхмаа, БТГ-ын СХНХХ-ийн шинжээч